



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/200/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn

Хэнтий аймаг

Чингис хот

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар

Утас: 70562112

Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Их наяд аудит ХХК-ийн

Захирал: Х.Ариунзул

Утас: 99077062

Цахим хаяг: ikhayadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23118 Хэнтий аймаг, Харлан сум, Сагсарь баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@auit.gov.mn

2024-03-11 № 028

талай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан, Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас багшийн сургалтад зориулж үнэ төлбөргүй шилжүүлсэн 50,210.9 төгрөгийн компьютерыг тоног төхөөрөмжийн дансанд хүлээн авч, хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж

2024.03.31

хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсрол олгох 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн төсвийг 93.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ж.ГАНБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	97,830,977.13	73,601,931.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,880,804.69	63,875,888.91
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	33,880,804.69	63,875,888.91
31210	Төгрөг	33,880,804.69	63,875,888.91
31211	Төрийн сангийн харилцах	33,880,804.69	63,875,888.91
33	АВЛАГА	12,600.00	-
33500	Бусад авлага	12,600.00	-
33510	Байгууллагаас авах авлага	12,600.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	63,937,572.44	9,726,042.68
35400	Хангамжийн материал	63,937,572.44	9,726,042.68
35460	Хүнсний материал	4,071,805.00	6,533,345.00
35470	Бусад хангамжийн материал	59,865,767.44	3,192,697.68
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,524,457,916.77	1,629,658,809.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,524,457,916.77	1,629,658,809.50
39200	Биет хөрөнгө	1,495,587,916.77	1,600,788,809.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,535,566,812.00	1,535,531,532.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(129,189,419.57)	(162,573,944.33)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	116,865,190.50	217,986,279.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,495,282.42)	(38,575,315.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,782,170.60	47,185,246.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,668,625.42)	(35,850,152.61)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,398,562.40	8,712,495.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,658,183.36)	(3,236,068.32)
39217	Ном	30,986,692.04	31,608,737.43
39300	Биет бус хөрөнгө	28,870,000.00	28,870,000.00
39301	Программ хангамж	560,000.00	360,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(560,000.00)	(360,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	28,870,000.00	28,870,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,622,288,893.90	1,703,260,741.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	79,684,687.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	79,684,687.00
41300	Өглөг	-	79,684,687.00
41360	Бусад өглөг	-	79,684,687.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	79,684,687.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,622,288,893.90	1,623,576,054.09
51	Засгийн газрын хувь оролцоо	1,622,288,893.90	1,623,576,054.09
51100	Засгийн газрын оруулсан капитал	425,725,809.40	425,725,809.40
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	425,725,809.40	425,725,809.40
51200	Хуримтлагдсан үр дүн	736,684,518.82	737,971,679.01
51210	Өмнөх үеийн үр дүн	(885,604,375.08)	736,684,518.82
51220	Тайлант үеийн үр дүн	1,622,288,893.90	1,287,160.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	459,878,565.68	459,878,565.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,622,288,893.90	1,703,260,741.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,428,134,824.67	1,057,995,744.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,640,036,624.67	57,911,944.67
120	Нийтлэг татварын бус орлого	1,640,036,624.67	57,911,944.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	950,900.00	1,695,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	950,900.00	695,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,571,373,652.23	55,009,665.39
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	67,712,072.44	1,206,779.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,098,200.00	1,000,083,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	681,052,900.00	901,565,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	681,052,900.00	901,565,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	107,045,300.00	98,518,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,045,300.00	98,518,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	805,845,930.77	1,056,708,584.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	805,845,930.77	1,056,708,584.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	764,620,021.37	1,004,657,259.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,812,046.69	619,946,467.59
210101	Үндсэн цалин	360,650,973.69	384,677,837.43
210102	Нэмэгдэл	99,099,118.00	213,797,114.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	13,061,955.00	21,471,515.30
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,073,299.62	77,540,660.20
210201	Тэтгэврийн даатгал	41,280,991.31	56,558,241.24
210202	Тэтгэмжийн даатгал	4,499,154.54	5,107,532.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,599,103.44	3,989,227.73
210204	Ажилгүйдлийн даатгал	871,733.71	983,703.15
210205	Эрүүл мэндийн даатгал	8,822,316.62	10,901,955.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,770,099.60	92,282,660.15
210301	Гэрэл, цахилгаан	6,577,079.60	7,596,596.15
210302	Түлш, халаалт	77,210,526.00	77,295,064.00
210303	Цэвэр, бохир ус	2,982,494.00	7,391,000.00
2105	Нормативт зардал	52,419,200.00	63,972,000.00
210502	Хоол, хүнс	52,419,200.00	63,972,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,100,000.00	3,265,000.00
210604	Урсгал засвар	2,100,000.00	3,265,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,378,900.00	6,217,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	950,900.00	695,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,428,000.00	5,522,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,066,475.46	141,432,871.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,617,600.00	83,993,599.04

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,590,300.00	2,949,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,858,575.46	54,490,272.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,225,909.40	52,051,324.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,560,000.00	49,815,184.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,560,000.00	42,792,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,023,184.99
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	665,909.40	2,236,139.85
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	665,909.40	2,236,139.85
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,622,288,893.90	1,287,160.19
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,622,288,893.90	1,287,160.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	789,049,100.00	1,001,779,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	950,900.00	1,695,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	950,900.00	1,695,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	950,900.00	1,695,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	950,900.00	695,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,098,200.00	1,000,083,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	681,052,900.00	901,565,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	681,052,900.00	901,565,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	107,045,300.00	98,518,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,045,300.00	98,518,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	743,225,455.31	946,787,402.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	743,225,455.31	946,787,402.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	698,335,245.91	892,278,167.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,909,058.11	619,946,467.59
210101	Үндсэн цалин	360,747,985.11	384,677,837.43
210102	Нэмэгдэл	99,099,118.00	213,797,114.86
210104	Урамшуулал	13,061,955.00	21,471,515.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,988,888.20	77,528,060.19
210201	Тэтгэврийн даатгал	41,196,579.89	56,545,641.23
210202	Тэтгэмжийн даатгал	4,499,154.54	5,107,532.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,599,103.44	3,989,227.73
210204	Ажилгүйдлийн даатгал	871,733.71	983,703.15
210205	Эрүүл мэндийн даатгал	8,822,316.62	10,901,955.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,770,099.60	92,282,660.15
210301	Гэрэл, цахилгаан	6,577,079.60	7,596,596.15
210302	Түлш, халаалт	77,210,526.00	77,295,064.00
210303	Цэвэр, бохир ус	2,982,494.00	7,391,000.00
2105	Нормативт зардал	49,454,300.00	63,975,630.00
210502	Хоол, хүнс	49,454,300.00	63,975,630.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,100,000.00	4,000,000.00

210604	Урсгал засвар	2,100,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,012,800.00	6,127,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	950,900.00	695,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,061,900.00	5,432,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,100,100.00	28,417,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,508,900.00	20,281,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,591,200.00	8,136,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,890,209.40	54,509,234.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,224,300.00	52,273,095.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,224,300.00	45,249,910.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	7,023,185.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	665,909.40	2,236,139.85
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	665,909.40	2,236,139.85
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	45,823,644.69	54,991,897.22
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,942,840.00	24,996,813.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,942,840.00	24,996,813.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,942,840.00	24,996,813.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,942,840.00	24,996,813.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(11,942,840.00)	(24,996,813.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	33,880,804.69	29,995,084.22
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	33,880,804.69
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,880,804.69	63,875,888.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	425,725,809.40	459,878,565.68	(885,604,375.08)	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	425,725,809.40	459,878,565.68	(885,604,375.08)	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,622,288,893.90	1,622,288,893.90
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,725,809.40	459,878,565.68	736,684,518.82	1,622,288,893.90

11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	425,725,809.40	459,878,565.68	736,684,518.82	1,622,288,893.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	425,725,809.40	459,878,565.68	736,684,518.82	1,622,288,893.90
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,287,160.19	1,287,160.19
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	425,725,809.40	459,878,565.68	737,971,679.01	1,623,576,054.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,035,659,700.00	969,548,075.93	66,111,624.07	93.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,035,659,700.00	969,548,075.93	66,111,624.07	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	978,010,300.00	917,274,980.93	60,735,319.07	93.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	671,960,200.00	619,946,467.59	52,013,732.41	92.3
210101	Үндсэн цалин	461,720,400.00	384,677,837.43	77,042,562.57	83.3
210102	Нэмэгдэл	182,004,300.00	213,797,114.86	(31,792,814.86)	117.5
210104	Урамшуулал	28,235,500.00	21,471,515.30	6,763,984.70	76.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,995,800.00	77,528,060.19	6,467,739.81	92.3
210201	Тэтгэврийн даатгал	57,117,300.00	56,545,641.23	571,658.77	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,719,600.00	5,107,532.19	1,612,067.81	76.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,375,700.00	3,989,227.73	1,386,472.27	74.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,343,900.00	983,703.15	360,196.85	73.2
210205	Эрүүл мэндийн даатгал	13,439,300.00	10,901,955.89	2,537,344.11	81.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,518,800.00	92,282,660.15	2,236,139.85	97.6
210301	Гэрэл, цахилгаан	10,511,200.00	7,596,596.15	2,914,603.85	72.3
210302	Түлш, халаалт	77,295,100.00	77,295,064.00	36.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,712,500.00	7,391,000.00	(678,500.00)	110.1
2105	Нормативт зардал	63,975,700.00	63,975,630.00	70.00	100.0
210502	Хоол, хүнс	63,975,700.00	63,975,630.00	70.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,127,600.00	6,127,600.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	695,500.00	695,500.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,432,100.00	5,432,100.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,432,200.00	53,414,563.00	17,637.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,284,100.00	45,278,063.00	6,037.00	100.0

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,148,100.00	8,136,500.00	11,600.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,649,400.00	52,273,095.00	5,376,305.00	90.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,649,400.00	52,273,095.00	5,376,305.00	90.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,587,700.00	45,249,910.00	5,337,790.00	89.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,061,700.00	7,023,185.00	38,515.00	99.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,035,659,700.00	999,543,160.15	36,116,539.85	96.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	901,565,000.00	901,565,000.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	901,565,000.00	901,565,000.00	-	100.0
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	98,518,800.00	96,282,660.15	2,236,139.85	97.7
320001	Орон нутгийн төсвөөс	98,518,800.00	96,282,660.15	2,236,139.85	97.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,575,900.00	1,695,500.00	33,880,400.00	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	695,500.00	695,500.00	-	100.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	33,880,400.00	-	33,880,400.00	-
4	"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	33,880,804.69		
5	"Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	63,875,888.91		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37	37	-	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	35	35	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан			-	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	315	315	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 100.5 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлснээс давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн хүснэгтээрх цалингийн зардлыг журналд дутуу бүртгэсэн.	1	100.5					1	100.5				
Дүн	1	100.5					1	100.5				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.